

МНТ-ы хүний нэрийн франц хөрвүүлэг

Н.Мөнх /МУИС, ГХСС/

Аннотация: *Вопрос перевода имён собственных неоднозначен и очень труден. Поэтому исследования переводов, транслитерации, транскрипции и транспозиции имён собственных “Сокровенного сказания монголов” являются важными для последующих трудов.*

Во французском переводе “Сокровенного сказания монголов” мы насчитали 428 имён из которых 285 переведены полностью, 56 частично переведены, 84 транскрибированны. В данном исследовании мы попытались сделать сравнительный анализ переводов “Сокровенного сказания монголов”.

Товч агуулга: Оноосон нэр, тэр дундаа хүний нэрийн орчуулга, хөрвүүлэг нь нэн төвөгтэй байдаг. Тиймдээ ч МНТ-ы хөрвүүлэг, орчуулга, галиг зэргийг харьцуулан/зэрэгцүүлэн үзэх нь цаашдын орчуулгын ажилд нэн тустай.

МНТ-ы франц орчуулгад нэр, нийт 428 нэр байснаас бүрэн орчуулсан нэр – 285, бүрэн бус орчуулсан нэр – 56 мөн 84 орчуулаагүй нэр байна. Бид уг өгүүллэгт франц хэлнээ галиглаж буулгасан нэрийг шүүж, бусад галиг, орчуулга, хөрвүүлэгтэй тулгаж олон эхийн ялгааг олохыг зорилоо.

Түлхүүр үг: *МНТ, хөрвүүлэг, орчуулга, хүний нэр, галиг.*

Сүүлийн үеийн орчуулгын онолд, тэр дундаа, барууны орчуулгын онолд оноосон нэрийн орчуулга, хөрвүүлгийн асуудал чухал байр суурь эзлэх болсон. Хэдий оноосон нэр, нэн ялангуяа, хүний нэрийг утгачилж орчуулж болох эсэх асуудал одоо хэрнээ нэг мөр болоогүй байгаа ч эл чиглэлийн судлагаа, шинжилгээний ажил нэмэгдсээр байна.

Дашрамд хэлэхэд, мэргэжлийн бус дийлэнхи хүмүүсийн тухайд оноосон нэрийн орчуулгыг хэт амархан, галиглаад бичихэд л хангалттай гэсэн ташаа ойлголттой байх нь элбэг. Гэтэл, энэ нь тийм ч амар зүйл бус юм, учир нь Charles гэдэг нэрийн тухайд л гэхэд уг хүний яс үндэс, угсаа гарлаас хамааран уг нэрийг монгол хэлнээ Чарльз, Шарль

бүүр тэр ч байтугай зарим тохиолдолд Карл ч гэж буулгаж болох талтай. Монгол нэрийг ч гадны хэлнээ буулгах асуудал хүнд, жишээ нь Алтан ордны улсыг үндэслэн байгуулагч Бат хааны нэрийг орос хэлнээ Бату, Батый гэж хэд хэдэн янзаар орчуулж хөрвүүлэх нь бий. Ийм олон жишээ дурьдаж болно.

Үндсэн асуудалдаа эргэн орёе, бид энэ чиглэлийн хэд хэдэн судлагааны ажил, бүтээл, зэрэг горилсон диссертаци зэрэгтэй танилцсан бөгөөд эдгээрийг тоймлоход нэрийг орчуулах/буулгах үндсэн 4 аргыг нэгэнтээ онцолдог болжээ: галиглах (transcription), үсгэчлэн буулгах (transliteration), тухайн хэлнээ дүйх нэрээр буулгах (transposition), орчуулах (translation).

а. Францаас монгол хэлнээ орчуулахад галиг нь хамгийн түгээмэл хэрэглээтэй арга бөгөөд галиг орчуулгыг авиалбарын түвшинд хийдэг. Жишээ нь: францын алдарт хүүхдийн зохиолч Charles Perrault, эл нэрийг [ʃa-ʁl pe-ʁo] хэмээн галигладаг бөгөөд монгол хэлнээ ч Шарль Перо гэж орчуулдаг байна. Мөн **ч, ц, х, ш, ө** зэрэг үсэг орсон нэрийг барууны хэлнээ галиглаж буулгах нь элбэг байдаг.

б. Үсгэчлэн буулгах арга – гол төлөв үсэг, заримдаа бүтээврийн түвшинд хэрэглэдэг. Барууны хэлнээс орчуулахад дуудлага, бичлэг хоёр нь зөрдөггүй нэрийн тухайд эл аргаар орчуулах нь элбэг: Александр – Александр, Gйrard- Жерард г.м. Монгол нэрийг барууны хэлнээ, тэр дундаа франц хэлнээ орчуулхад эл аргыг хэрэглэх нь элбэг: Эрдэнэ – Erdene, Номин-Nomin, Дамдинсүрэн-Damdinsuren г.м.

в. Дүйх нэрээр буулгах – энэ аргыг манай орчуулгын уламжлалд дорнын хэлнээс орчуулахдаа хэрэглэсээр ирсэн. Гэхдээ өрнийн хэлнээс орчуулахдаа эл аргыг бараг хэрэглэдэггүй байна, энэ нь монгол болон өрнийн буюу бидний хэлж заншиснаар барууны түүх, соёлын ялгаатай холбоотой болов уу. МНТ-г франц хэлнээ орчуулхад энэ аргыг тоотой хэдэн удаа хэрэглэсэн байгаа нь сонирхолтой – МНТ-нд гарах Ю-Хунан⁵⁷ хэмээх нэрийг Р. Поп, Мари-Доминик Эвен нар *Johannis*⁵⁸ хэмээжээ. Вангийн чинсан хэмээх цолыг орчуулагчид Premier minister Wan-Yen (Ерөнхий сайд Ван Янь) хэмээн оноосон нэр болгон орчуулсан нь мөн л дүйлгэх арга бөгөөд бидний анхаарлыг татлаа,

⁵⁷ Ц. Дамдинсүрэн, МНТ, УБ, 1996, т.139

⁵⁸ Marie-Dominique Even, Rodica Pop, Histoire Secrite des Mongols, Saint-Amand, 1994, т.149

учир нь МНТ, Алтан товч г.м. хөлгөн судрыг шүтэж, уншисаар ирсэн монгол хүний хувьд Вангийн чинсан хэмээх цол нь нангиад, өөрөөр хэлбэл тухайн хүн ч нангиад иргэн байх нь тодорхой мэт санагднаа, гэтэл уг үгийг галиглах эсвээс шууд орчуулваас франц уншигч ийн ойлгох нь юу л бол, тиймдээ ч **вангийн** хэмээх үгийг Wan Yen хэмээн орчуулснаар цаад хүнийг нь нангиад болохыг нь тодоос тод ойлгуулж байна. Эл орчуулга нь утга, хэлбэрийн хувьд буруу мэт боловч монголын түүх соёл сайн мэдэхгүй уншигч олонд илүү хүртээмжтэй мэт санагдана.

г. Нэр шууд утгачилан орчуулах арга нь өдөр тутмын амьдралд бус, гол төлөв уран зохиолын орчуулгад л байдаг хэмээн үздэг байна. Зохиолын баатрын нэр нь уг зохиолын утгыг агуулж, зангилаа нь болж байгаа нөхцөлд уг нэрийг орчуулах нь зүйтэй: Cendrillon – Үнсгэлжин г.м. Мөн хүний хоч нэр, хэргэм зэргийг, заавал ч уран зохиол гэлтгүй, бараг дандаа орчуулдаг байна.

Бид МНТ-ы франц орчуулгыг нэгбүрчлэн шүүж үзэхэд нийт 428 нэр⁵⁹ байснаас бүрэн орчуулсан нэр – 285, бүрэн бус орчуулсан нэр – 56 мөн 84 орчуулаагүй нэр байна. Оноосон нэр тур дундаа хүний нэрийг өөр хэлнээ буулгах нь нэн хүнд, тиймдээ ч Р. Поп, Мари-Доминик Эвен нарын МНТ-ы франц орчуулга нь оноосон нэр, монгол хүний нэрийг орчуулж, галиглаж, үсгэчилсэн гэдгээрээ нэн үнэтэй бүтээл бөгөөд цааш цаашдын орчуулагчидад чухал суурь, дэм болж өгнө. Эл орчуулгад анализ хийснээр цаашдаа монгол хүний нэр, тэр дундаа уран зохиолын баатрын/дүрийн нэрийг хэрхэн франц хэлнээ буулгах аргачлалыг тогтоож болох мэт санагдана. Ийн хүний нэрийг орчуулах, галиглах аргачлалыг тогтоож, гадаад хэлнээ орчуулсан монголын уран зохиолын орчуулгын тоог нэмэх нь өөрийн хэл-соёлоо хадаглах, сурталчилахад ач холбогдолтой.

Бид судлагаагаа утгачилж орчуулаагүй зөвхөн галиглаж, үсгэчилсэн (хөрвүүлсэн) нэрийн ажиглалтаас эхлэх нь зүйтэй гэж үзлээ. Эдгээр нэрийг шүүж карт бүрдүүлэх явцад бид хэд хэдэн галиг, орчуулга, хөрвүүлэг⁶⁰ зэрэгийг харьцуулж үзсэн бөгөөд эдгээрт⁶¹ зөрөх, таарч тохирохгүй зүйл их байгааг энд дурдъя:

⁵⁹ үүнд хятадын Алтан хаан, Султан халиф г.м. хэргэм зэрэг мөн орсон байгаа.

⁶⁰ 1. Marie-Dominique Even, Rodica Pop, Histoire Secrite des Mongols, Saint-Amand, 1994; 2. Paul Pelliot, Histoire secrte des Mongols, Paris, 1949; 3. И. де Рахевильц, The Secret History of the Mongols, 1972; 4. Ц. Дамдинсүрэн, МНТ, УБ, 1996; 5. Лувсанданзан, Алтан товч, УБ, 2006; 6. Ш. Чоймаа, Монголын Нууц Товчоон, УБ, 2006

⁶¹ зөвхөн галигласан, үсгэчилсэн нэрийн зөрөөг л дурьдсан болно

1. МНТ-ы 120-р зүйлд буй *Cilgьtei* хэмээх нэрийг харьцуулж үзвээс (дарааллыг доорхи зүүлт 4-с харна уу):

1.	<i>Cilgьtei</i>	<i>Cilgьtei, Taqai et Le Prince, aonys et cadets des Emblimes, arrivaient йgalement</i>	85т.
2.	Їilgьтди	<i>De chez les Suldus, Їilgьтди, Такп, Таупнп’удап, les friges aonys et les friges cadets, vinrent йgalement</i>	154т.
3.	<i>cilgьtei</i>	<i>suldus-aca cilgьtei taki tayici’udai aqa-nar de’ь-neg ireba-гь</i>	50т.
4.	Чилэгүтэй-Тахи	Сүлдүс аймгаас Чилэгүтэй-Тахи, Тайчиудай ах дүү нар ирэв	57т.
5.	Чилгүдэй	Сүлдүсээс Чилгүдэй, Тахай, Тайчуудаас ах нар дүү нар ирвэй л	75т.
6.	Чилгүдэй	Сүлдүсээс Чилгүдэй, Тахай, Тайчуудай ах нар дүү нар ирэв	67т.

гэж бичсэн байна. Дээрхээс үзэхэд Ц. Дамдинсүрэн гуай *Cilgьtei, Taqai* хэмээх хоёр хүний нэрийг 1 хүний нэр байна гэж үзсэн нь илт байна. Бусад судлаачид эдгээр үгсийг 2 хүний нэр гэж үзсэн байна. И де Рахевильц эл өгүүлбэрийг *suldus-aca cilgьtei taki tayici’udai aqa-nar de’ь-neg ireba-гь* хэмээн галигласан бөгөөд эл галигаас хэдэн нэр байгааг шууд тогтоох хэцүү мэт санагдсан тул бид англи орчуулгыг нь лавлаад *From the Suldus also came the brothers Їilgьtei, Taki and Tayncn’udai.* хэмээн хөрвүүлсэн байхыг нь оллоо. Өөрөөр хэлбэл, Рахевильц ч *Їilgьtei, Taki* хэмээх хоёр хүн байна гэж үзсэн бөгөөд түүний судлагаанд тэмдэглэснээр *Taki* гэдэг нэрийг §§151, 156-д *Taqai*; §126 *Daqai* гэж тус тус бичжээ.

Дараагийн нэг зүйл бол Алтан товчид *Сүлдүсээс Чилгүдэй, Тахай, Тайчуудаас ах нар дүү нар ирвэй л* хэмээснээс үзэхнээ Тайчууд гэдэг нь хүний нэр бус овгийн нэр мэт байна.

2. Бидний анхаарлыг татсан өөр нэгэн хэсэг бол 141-р зүйлд буй [*les Qorolas*] *menüs par Conaq et Blanc des Qorolas* хэмээх өгүүлбэр юм. Бидний олж үзсэн орчуулгаас үзэхэд хоёр франц орчуулгын аль алинд нь Чоёг, Цагаан гэсэн хоёр нэр байна харин бусад судлаачид Чоёг цагаан, Алтан товчийн тухайд Чиндан цагаан гэж нэг хүний нэрээр буулгасан байна.

3. 102-р зүйлийн *Darmala des Qa'ad, des Bons Viseurs de Qa'ad* хэмээх нэр. Цухас харахад эл нэрийн орчуулгад бүгд санал нийлж, зөрөөгүй буулгасан байгаа мэт боловч Р. Поп, Мари-Доминик Эвен нарын орчуулгыг үгчлэн орчуулваас *Хаад мэргидийн Хаадын Дармала* гэсэн нэр гарч ирж байна, өөрөөр хэлбэл, *des Qa'ad* гэдгийг нэг бол Хиад ясны Боржигон овог гэдэг шиг яс үндсээр харьяалуулж эс бөгөөс өгүүлбэрзүйн үүднээс *Хаад, хаад мэргидийн, Дармала* гэж нэмэлт тодотгол гишүүн ашигласан мэт ойлгогдож байна. Даширамд дурьдахад, монгол хэлний -тай⁴ бүтээвэр/дагаварыг орчуулагчид франц хэлний *le, la, l'* хэмээх тодорхой ялгацаар буулгах хандлага ажиглагдаж байна (*Le Vesъd-Бэсүдэй, L'Oungour-Уйгуртай, Le Djourtchite –Жүрчидэй, Жорчидай г.м.*).

4. МНТ-ы 47 зүйлд буй *Oronar, Sonnaillers, Arulad, Nuits, Qabturqas, Geniges* зэрэг франц хөрвүүлгийг үзвээс эдгээр нь хүний нэр бус зөвхөн овгийн нэрс байгаа мэт ойлгогдож байна. (Гэтэл дараахи зүйлүүдэд эдгээр нь хүний нэр болж хувирч байна, жишээ нь: 202-р зүйлд *Ogonar* гэдэг нь хүний нэр байна). Ц. Дамдинсүрэн гуай эдгээр үгсийг хүний нэр хэмээн үзсэн бөгөөд И де Рахевильц ч мөн эдгээрийг эл зүйлд овгийн хийгээд хүний нэр байна гэж үзэн буулгасан байна⁶².

5. 248 зүйл. *Гьнгjь* хэмээх нэр. Судалгаа, орчуулга, галиг зэргээс эл үгийг харахад хүний нэр байгаа мэт байна⁶³, гэтэл Ц. Дамдинсүрэн гуай эл нэрийг хүний нэр бус хэргэм байна гэж үзжээ⁶⁴. С. А. Козин ч мөн галигтаа “Гүнж нэртэй охин” хэмээн галигласан хэрнээ орчуулгадаа уг үгийг хэргэм болгож орчуулсан байна. И. де

⁶² Igor de Rachewiltz, *THE SECRET HISTORY OF THE MONGOLS, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*, Vol. I, Boston, 2004, т. 9

⁶³ аливаа галигаас үзэхнээ Гүнж нэрт охин гэж бичсэн байна

⁶⁴ Ц. Дамдинсүрэн, МНТ, УБ, 1996, т. 208

Рахевильц ч мөн 2004 онд хэвлүүлсэн номын зүйлт тайлбарт гүнж гэдэг нь хүний нэр бус хятадын хэргэм зэрэг хэмээн бичсэн байна.

6. Jцngsei (120 зүйл), Jьngsei (202 зүйл) хэмээх нэрсийг Ц. Дамдинсүрэн гуай аль алийг нь Жунсо хэмээн нэг нэрээр буулгажээ. Бусад судлаачид Ш. ЧОЙМАА БАГШИЙН НОМЫГ ХАРАХ хоёр хүн байна хэмээн үзжээ. Гэхдээ бидний үзэж буйгаар Ц. Дамдинсүрэн гуай зөв буулгасан байж болох мэт санагдана учир нь Чингис хаанд анх дагаар орж байсан ноёд бараг бүгд хожуу мянгатын ноёд болцгоосон тул хятад үсгээр бичсэн эхийг бүтээсэн хүн алдсан ч байж болох талтай (§§120, 203 тус тус үзнэ үү)⁶⁵.

7. Le Djourtchite хэмээх нэр §§130, 183 тус тус гарч байгаа бөгөөд Ц. Дамдинсүрэн эл нэрийг §130 Жүрчидэй, §183-т Жорчидай хэмээн буулгасан байна. Бусад эрдэмтэн, мэргэдийн бүтээлээс эл нэрийг шүүж үзвээс бүгд нэг маягаар, нэг хүн болгож орчуулсан байна. Эл нэрийн тухайд Ц. Дамдинсүрэн гуай алдсан байх талтай.

8. 170-р зүйлд буй Чихитай, Ядир хэмээх нэрс. Судлаачид нэг хүн үү, хоёр хүн үү гэдэгт эргэлзсээр ирсэн. Ш. Чоймаа багш эдгээрийг нэг хүний нэр байна хэмээн үзсэн бөгөөд бидний гол хэрэглэгдэхүүн болгож хэрэглэсэн бусад бүтээлд ч энэ нь нэг хүний нэр байгаа С. А. Козин үүнийг хоёр хүний нэр болгож орчуулсан байна.

⁶⁵ 120-р зүйлд Чингис хаанд дагаар орсон 34 хүний нэр байгаагаас хожуу 20 нь мянгатын ноён болсон байна. (202-р зүйл)

Судлагааны явцад бид нэмэж МНТ-ы хэд хэдэн галиг, орчуулга, хөрвүүлэг зэргийг олж үзсэн бөгөөд хэдий нарийвчлан судлагаа хийгээгүй ч судлаачид эдгээр нэрсийг хэрхэн буулгасаныг энд нэгтгэн оруулж цаашдын судлагаанд дөхөм болох нь зүйтэй мэт санагдлаа. Иймд МНТ-ы франц орчуулгын 83 орчуулаагүй (үсгэчилсэн⁶⁶) нэрийг орчуулагч, судлаачид дараахи байдлаар буулгасан байгааг хүснэгтлэн орууллаа. Бид эдгээр нэрсийг бүгдийг нь нэг хүснэгтэнд багтааж чадаагүй тул хоёр тусдаа хүснэгт болгож оруулсанд хүлцэл өчье.

Хүснэгт А.

Мари-Доминик Эвен, Р. Поп	Лу. Алтан товч	Ц. Дамдинсүрэн /шинэ үсгийн хөрвүүлэг/	П. Пеллио /франц орчуулга/	П. Пеллио /галиг/	С. Козин /орос орчуулга/	С. Козин /галиг/	П. Поуха /чех орчуулга/	И. де Рахевильц /галиг/	И. де Рахевильц /англи орчуулга/
Amal	-----	Амал	-----	Amal	Амал	Amal	Amal	amal	Amal
Ambaqai	Исалай	Амбагай	Амбагай	Амбагай- qahan	Амбагай - хаган	Амбагай- qapan	Ambachaj shahan	ambaqai	Ambaqai Qa'an
Agulat	Аралун	Арулад	Агулат	Agulat	Арулад	Agulat	Agulat	agula[t]	Agulat
Badai	Бадай	Бадай	Вадап	Badai	Бадая	Badai	Badaj	badai	Badai
Baqaji	-----	Бахажи	Вадап	Baqaji	Бахарчжи	Baqaji	Bachadziho	baqaji	Baqaji
Вегде	-----	Бэрүүд	-----	baruda ⁶⁷	Беруде	berude	Вегде	beγde	Вегде
Во'орсу	Боорчи	Боорчи	Во'орсу	Во'орсу	Боорчу	Воорсу	Воорсу	bo'orsu	Bo'orsu
Вугидай	Бөхэтэй	Бүхэдэй	-----	Вьгид	Бугидай	Вугидай		вьгидеи	Вьгидеи
Вьжек	-----	Бужиг	-----	Вьдж	Бужек	Bujek	Вьжек	вьjek	Вьjek
Bulqadar	-----	Булхадар	-----	Bulqadar	Булхадар	Bulqadar	Bulachadar	bulqadar	Bulqadar

⁶⁶ Хоёр хэлний үзүй, авиазүйн онцлог, ялгаанааг харгалзан нэрийг үсгэчилэх зарчим баримталсан хэмээн орчуулагчид бичсэн байна

⁶⁷ /жижиг үсгээр бичсэн тул нэр гэж үзээгүй бололтой/

Sanai	Чанай	Чанай	-----	Санап	Чанай	Санап	Чанай	Санап	Санап	Санап	санай	Санап
Sanar	-----	Чанар	-----	Санаг	Чанар	Санаг	Чанар	Санаг	Санаг	Санаг	санар	Санаг
Saujin Цртеgei	Чаужин өргэгэй	Чаужин өргэгэй	Сәуйпн- иртгдлi	Сәуйпн- иртгдлi	Чаожин - Ортегай	Сәуйпн- Ортекай	Чаожин - Ортегай	Сәуджин – Цртеgeje	Сәуджин – Цртеgeje	Сәуйпн-цртеgei	саужин-цртеgei	Сәуйпн Öртеgei
Sigidaı	Чигидэй	Чихитай	Сигидап	Сигидап	Чихитай- Ядир	Сикитай- Ядир	Чихитай- Ядир	Сигидаж	Сигидаж	cigidei yadir		Сигидеi
Сигьтеi	Чилгүдэй	Чилэгүгэй-Тахи	Сигьтдi	Сигьтдi	Чильгугай- Таки	Силкутай- Таки	Чильгугай- Таки	Сигьтеj	Сигьтеj	cigьtei		Сигьтеi
Сонаq	Чиндан цагаан	Чоёг цагаан	Сонаq	Соуоq	Чоёх-Чахаан	Сәуоуq- Сәгаан	Чоёх-Чахаан	Сһонаch	Сһонаch	soyоq-saqа'an		Сһонаq Саqа'an
Сормаqан	Чирахан	Чормаган	-----	Сормаqан	Сормаган	Сормаган	Сормаган	Сормаqан	Сормаqан	сормаqан		Сормаqан
Сотан	Жоган	Цотан	Сотан	Сотан	Цотан	Сотан	Цотан	Сотан	Сотан	сотан		Сотан
Darbai	Дарбай	Дарбай	Darbai	Darbai	Дарбая	Darbai	Дарбая	Darbai	Darbai	darbai		Darbai
Darmala des Qa'ad, des Bons Viseurs de Qa'ad	Хаатай Дармала	Хаад мэргэдийн Хаатай Дармала	Qa' атап- Darmala des Qa'at- Mlrkit	Млрkid-ын Qa' атап- Darmala	Хаатай-Дарм ала из Хааг-Мерки тского рода	Qaat- Merkidun Qaatai- Darmala	Хаатай- Дармала	Chaataj- Darmala	Chaataj- Darmala	qa'at-merkid-ын qa'atai-darmala		Qa'atai Darmala of the Qa'at Merkit
Davun	-----	Даун	-----	Davun	Давун	Даун	Давун	Davun	Davun	davun		Da'un
Ebegei	Эбэхэй	Эбэхэй	Дьдгдi	Абдгдi	Эбегай	Ебекай	Эбегай	Ebegeji	Ebegeji	ebegei		Ebegei
Geniges	Гийл Хэргис	Хэнигис	Гдигдs	Гдигдs	Генигес	қениқes	Генигес	Geniges	Geniges	geniges		Geniges
Гьngjь	-----	-----	-----	Гьngjь	-----	қunju	-----	Гьngдзь	Гьngдзь	gungjь		Gungju
Һнбуgetьr	Бөгэгүр	Хөвөгэгүр	-----	Һнбуgetьr	Хобегегүр	Нобекетур	Хобегегүр	Һнбуgetьr	Һнбуgetьr	Һнбуgetьr		Һнбуgetьr
Ибаqа	Ибага бэх	Ибага	-----	Ибаqа-бдki	Ибаха-беки	Ибаqа-беки	Ибаха-беки	Иbacha-beki	Иbacha-beki	ibaqa-beki		Ибаqа Beki
Iduqadaı	Индугтай	Идухалай	-----	Iduqadaп	Идухалай	Iduqadaı	Идухалай	Idochudaj	Idochudaj	iduqadaı		Iduqadaı
Иле	Илэ	Илэ	-----	Ил	Иле	Иле	Иле	Илеа	Илеа	ile		Иле

Итрген	-----	Итүргэн	Идыргдн	Идыргдн	Идыргдн	Идүрген	Идүргөн	Идырген	идырген	Идырген
Jamuqa	Жамуха	Жамуха	Јамуqа	Јамуqа	Јамуqа	Чжамуха	Јамуqа	Džamucha	jamuqa	Јamuqа
Jebke	Жэбгэ	Зэвгээ	Јдбкд	Јдбкд	Јдбкд	Чжебке	Јдбкд	Džebke	je[b]ke	Јebke
Jeder	-----	Жилэр	-----	-----	Јддр	Чжелер	Јддр	Džedej	jeder	Јeder
Jegь	-----	Жэхү	-----	-----	Јдгь	Гучжей	Јдгь	Jegьe	jegь	Јegь
Jelme	Зэлмэ	Зэлмэ	Јдлмд	Јдлмд	Јдлмд	Чжелме	Јдлмд	Dželme	jelme	Јelme
Jetei	Жэлэй	Жагай	Јдтд	Јдтд	Јдтд	Чжетай	Јдтд	Džetej	jetei	Јetei
Jungsei	Жүнхэ	Жунсо	Јунгсд	Јунгсд	Јунгсд	Чжунсу	Јунгсд	Džungso	jungso	Јungso
Jubqan	Жаухан	Жубхан	-----	-----	Јубqаn	Чжубхан	Јубqаn	Džao-go	jubqan	Јubqan
Jyngsei	-----	Жунсо	-----	-----	Џунгсд	Чжунсу	Јунгсд	Džongšo	jungšoi	Јungšoi
L'Empereur	Богд Чингис хаан	Чингис хаан	Џингс-qahan	Џингс-qahan	Џингс-qahan	Чингис-хан	Џиңкис-qаған	Џinggis-qahan	Сinggis-qahan	Џinggis Qa'an
L'Ouigour	-----	Уйгуртай	-----	-----	Ул'уртап	Уйгуртай	Тууртай	Uurtaj	ui'urtai	Ui'urtai
Lablaqa	Албала	Лаблах	-----	-----	Lab-laqa	Лаблаха	Lablaqa	Lablacha	lablaqa	Lablaqa
Le Besьd	Бэсүд	Бэсүдэй	Вдсьд	Вдсьд	Вдсьд	Бесутай	Besutai	Besьtei	besьtei	Besьtei
Le	Жүрчидэй	Жүрчидэй	Јыгддд	Јыгддд	Јыгддд	Чжурчедай	Јурчедд	Džьгсдеј	јыгсedei	Јьгсedei
Djourtchite	Жүрчидэй	Жорчидэй	Јыгддд	Јыгддд	Јыгддд	Чжурчедай	Јурчедд	Džьгсede	јыгсedei	Јьгсedei
Le Jalair	-----	Жалайрдай	-----	-----	Јалауртап	Чжалаиртай-хорчин	Јалаиртай	Džalairlaj	јалауртай	Јalairtai Qorči
Le Je'ьren	Жэгүридэй	Жаурьдай	Јдвьгддд	Јдвьгддд	Јдвьгддд	Чжоуредай	Јаouredai	Dževuredeje	јевьгredei	Јe'ьredei
Le Kinggiyan	Хингиадай	Хингиадай	Кпнгггуа	Кпнгггуа	Кпнгггуа	Кингиадай	Қиңгиyаdai	Kinggiyadaj	kinggiyadai	Kinggiyadai

Le Siju'un	Шижуудай	Шижуудай	Шижуудай	Шижуудай	Шижуудай	Шижуудай	Шижуудай	Sidzuudaj	siju'udai	Šiju'udai
Le Tьгь'ьп	Түгүдэй	Тугудай	Тьгь'ьфдї	Тьгь'ьфдї	Тьгь'ьфдї	Тухуудай	Тухуудай	Tьгь'ьdej	т'ьгь'ьdei	Tьгь'ьdei
Mas'ьid	Масгуд	Масхуд	-----	Masqut	Masqut	Масхут	Масхут	Maschut	masqut	Masqut
Mцngгь'ьг	-----	Мүнгүүр	-----	Mцngгь'ьг	Mцngгь'ьг	Мүнгүүр	Мүнгүүр	Mьngгььг	mцngгь'ьг	Mцngгь'ьг
Mьге	-----	Мүгэ	-----	Мьгд	Мьгд	Мүгэ	Мүгэ	Мьге	mьge	Мьге
Мьлke Totaq	Мүлэхэ	Мүлэхэ-готаг	Мькл- totaq	Мькл- totaq	Мькл- totaq	Мүлхэ-Готах	Мүлхэ-Готах	Мьлke- Totach	мьлke-totaq	Мьлke Totaq
Mулqalqu	Мулхалху	Мулхалху	Mулqalqu	Mулqalqu	Mулqalqu	Мулхалху	Мулхалху	Mулchalchu	mulqalqu	Mулqalqu
Naya	Наяа	Наяа	Naya'a	Naya'a	Naya'a	Наяа	Наяа	Naja	naya'a	Naya'a
Onggiran	-----	Хонгиран	-----	Onggiran	Onggiran	Унгиран	Унгиран	Unggiran	onggiran	Onggiran
Orbai	Өрбэй	Орбай	Orbai	Orbai	Orbai	Орбай	Орбай	Orbai	orbei	Црbei
Soqatai	Хохагай	Сохагай	Soqatai	Soqatai	Soqatai	Сохагай	Сохагай	Soqataj	soqatai	Soqatai
Orebeg	Өрвэг- Дигиди	Өлбэг-пигин	-----	Цдлбдк- digin	Цдлбдк- digin	Олбөк-диги н	Олбөк-диги	Цре- beg- digin	цребек-digin	Цребек Digin
Oronar	Орунар	Оронар	Oronar	Oronar	Oronar	Оронар	Оронар	Oronar	oronar	Oronar
Qabturqas	Хавурхад	Хабтурхас	Qabturqas	Qabturqas	Qabturqas	Хабтурхас	Хабтурхас	Chabturchas	qabturqas	Qabturqas
Qada	Хадагу	Хада	-----	Qada	Qada	Хада	Хада	Chada	qada	Qada
Qaidu	Хайду	Хайду	Qaidu	Qaidu	Qaidu	Хайду	Хайду	Chaidu	qaidu	Qaidu
Qasi	Хасар	Хаши	Qašp	Qašp	Qašp	Хаши	Хаши	Chašim	qasi	Qaši
Qorqudaq	-----	Хорхудаг	-----	Horqudaq	Horqudaq	Хорхудаг	Хорхудаг	Chorchudach	horqudaq	Horqudaq
Qudu'udar	-----	Худуудар	Qutu'udar	Qutu'udar	Qutu'udar	Худуудар	Худуудар	Chuduudara	qudu'udar	Qudu'udar
Qulbari	Илхабури	Хулбары	Qulbari	Qulbari	Qulbari	Хулбары	Хулбары	Chulbari cho	qulbari	Qulbari
Sali Qaca'u	Сали Халчагу	Саль-хачау	Salp- Qaca'u	Salp- Qaca'u	Salp- Qaca'u	Сали-Хачау	Сали-Хачау	Sali chaçau	sali-qaca'u	Sali Qaca'u
Seci'ьг	Сэчэгүр	Сэчирүр	Сдл'ьг	Сдл'ьг	Сдл'ьг	Сечирүр	Сечирүр	Seçür	seci'ьг	Seçi'ьг

Siki Quduqu	Шихихутуг	Шихихутуг	Şikikdn- Quduqu	Şikikdn- qutuqu	Шикикан- Хууху	Şikikan- Quduqu	Şigiken – Chutuchu	sikiken-qutuqu	Şikiken Qutuqu
Siki'yr	Шихурч	Шихур	Şikp'yr	Şikp'yr	Шикиру	Şikiur	Şiki'yr	siki'yr	Şiki'yr
Sultan Calife	Халибай султан	Халиф султан	-----	-----	Халибо- Солтан	Qaliba- soltan	Soltan Chalibaj	qalibai-soltan	Qalibai Soltan
Sultan Djalal ad Don	Жалалдин султан	Жалалдин султан	-----	-----	Чжалалдин- Солтан	jalalidin- soltan	Soltan Dzalalidin	jalalidin(g)-soltan	jalalidin Soltan
Tamasa	Тамачан	Тамача	Tamasa	Tamasa	Тамача	Tamasa	Tamasa	tamasa	Tamasa
Taqai	Тахай	-----	Takp	Takp	-----	-----	Taki	taki	Taki
Tobuqa	-----	Тобуха	-----	-----	Тобуха	Tobuqa	Tobucha	tobuqa	Tobuqa
Tiregene	-----	Дөргэнэ	-----	-----	Дорегене	Dorekene	Diregene	diregene	Diregene
Tungquidai	-----	Тунхуйдай	-----	-----	Тунгуйдай	Tungquidai	Tungchuida	tungquidai	Tungquidai
Turuqan	Тархулад	Турухан	-----	-----	Турухан	Turuqan	Turuchan	uruqan	Turuqan
Tusaqa	Тасаг	Тусаха	Tusaqa	Tusaqa	Тусаху	Tusaqa	Tusacha	tusaqa	Tusaqa
Yadir	Едэр	Ядир	Yadir	Yadir	-----	-----	Jadir	-----	Yadir
Yalbaq	-----	Ялбаг	-----	-----	Ялбах	Yalbaq	Yalbach	yalbaq	Yalbaq
Yegь	-----	Егү	Yegь	Yegь	Егү	Yegь	Jegьe	yegь	Yegь
Yuruqan	-----	Юрухан	-----	-----	Юрухан	Yuruqan	Juruchan	yuruqan	Yuruqan

Ашигласан ном зохиол:

1. Marie-Dominique Even, Rodica Pop, Histoire Secrete des Mongols, Saint-Amand, 1994.
2. Paul Pelliot, Histoire secrete des Mongols, Paris, 1949.
3. И. де Рахевильд, The Secret History of the Mongols, 1972.
4. Ц. Дамдинсүрэн, МНТ, УБ, 1996.
5. Лувсанданзан, Алган товч, УБ, 2006.
6. Ш. Чоймаа, Монголын Нууц Товчоон, УБ, 2006.
7. С. А. Козин, Сокровенное сказание или Монгольский обьденный изборник, М-Л, 1941.
8. Igor de Rachewilyz, The Secret History of the Mongols, *A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*, Brill Leiden, Boston, 2004.
9. Pavel Poucha, TAJNĚ KRONIKA MONGOLŮ, Praha, 1955.